

В Притомье много уникальных исторических мест и достопримечательностей, пока ещё не так хорошо известных туристам. Открыть для себя новые уголки, получить незабываемые и захватывающие впечатления может каждый любознательный путешественник.

В настоящее время ведётся разработка туристского маршрута «По следам древних охотников до истоков культуры» – по памятникам древнего наскального искусства эпохи бронзы и раннего железного века, расположенных вниз по течению реки Томи от устья реки Крутой до села Поломошное Яшкинского района – это писаницы Новоромановская, Висячий камень, Тутальская и др. На Тутальской писанице можно увидеть самые большие на Томи изображения лосей, у реки Крутой – изображение самой длинной в Евразии лодки. Маршрут предполагает участие туристов в копировании наскальных рисунков и раскопках. Маршрут рассчитан на разные категории посетителей. Он может быть водным (доставка на катерах), конным, пешеходным, джиппинг.

Осмотр памятников можно совместить с прекрасным отдыхом на природе и рыбалкой, сбором ягод, трав, грибов. Маршрут может быть рассчитан как на уик-энд, так и быть однодневным. Однодневный маршрут – маршрут экскурсионно-образовательный.

Также существует проект экскурсионных маршрутов по прибрежным деревням и городам Притомья – от «Томской писаницы» до Томска. С 400-летней историей освоения Притомья русскими можно ознакомиться, посетив деревни Юргинского и Яшкинского районов, в которых сохранились деревянные дома XVIII – XIX веков.

Также в музее развивается музейно-практическая деятельность, которая предполагает открытие новых экспозиций: этнографической «Русское село» и реконструкцию экспозиции «Время, Космос, Календари» с учётом новых, более интересных для посетителя современных средств представления музейного материала.

Главным условием успешного развития туризма в Кузбассе как части внутреннего туризма является совместная деятельность учреждений культуры, представителей туристского бизнеса, инвесторов и власти. Только объединив усилия, можно достойно представить историко-культурный и природный потенциал Кузбасса на туристском рынке.

## Ц. Эрдэнэчулун

### ТҮҮХ, СОЁЛЫН ЦОГЦОЛБОРУУДАД МУЗЕЙН БҮРДҮҮЛБЭР, МЕНЕЖМЕНТИЙГ НЭВТРҮҮЛЭХ НЬ

*Түлхүүр уг:* Түүх соёлын цогцолбор, дотоодын зочин, жуулчин, музейн бүрдүүлбэр.

Шинэчлэл өөрчлөлт, ардчилалын эхний жилүүдэд орон нутгийн ард түмэн соёлын өвийг сэргээх, хэлмэгдсэн дурсгалыг нэхэх, түүний дотор шашны зан үйл, уламжлалыг нутаг, ах дүүсээрээ хүндэтгэн эхэлсэн бол 1990-ээд оны дунд үеэс зарим сүм дуган, уул, хадны бичээс, суврага, бурхадыг дахин өөрсдийн санаачлага, сэтгэлээр бүтээж даруйхан хугацаанд Улиастай хотод Хутагт хувилгаадын суврагууд /2004 он/, Зайсанд бурхан багшийн сэргэг дүр /2005 он/, “Амарбаясгалан хийд-Хос баясал” томоохон босгомжууд /2009 он/, Хамрын хийдийн музейн маршрут /2007 оноос/, Булган хангайн өвөрт Заяын хийд музейн байгууламж /2011 он/, Орос-Монголын хамтарсан Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгөөр Азидаа хамгийн том Бурхан багшийн мэлмий цогцолбор /2013 он/, Эв нэгдлийн билэгдэл-Их майдар /2014 он Төв аймаг/ хэдийнээ төр засгийн дэмжлэг, үйлдвэр аж ахуйн нэгж, олон нийтийн хандив, их хөрөнгөөр бий болов. Дархан хотын Бурхантын хөндий дэх дүрийг /2003 он/ анх удаа чулуун цутгуурын аргаар урласан бол сүүлийн цогцолборуудыг алтадсан нь Энэтхэг, Малайз, Тайланд орны буддын соёл, түүнийг баясгаласан азийн ерөнхий шинж онцлогыг

харуулж эрхэм тансаг, мөнхөд бишрэх дурсгалууд шинэ өнгө төрхөөр бүтсэнээр дотоодын төдийгүй гадаадын жуулчдын төв азид үздэг аялал жуулчлалын үзмэр, уран барилга, зориулалтын байгууламж, аялал жуулчлалын цогцолборууд баригдсан байна.

Харин зарим суврага цогцолборт очиход дэг, тайлбарлагч угүй, зохион байгуулалт, төлөвлөлт сайнгүй тул, түүх соёлын цогцолборуудын менежментийг сайжруулах шаардлага байгаа юм.

Алдарт Орхоны хөндий, Хархорин, Эрдэнэ зуу, Мэгжид Жансрайсаг, Балдан барайвун зэрэг томоохон туурь, хийдүүд, ордон, үндэсний музей, орон нутаг, сумын музейнууд нь хөгжлийн явцад эх орноороо бахархах, түүх уламжлалаа өвлүүлж сурталчилаад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн.

2000 оноос аялал жуулчлалын үндэсний чуулга уулзалтуудыг хийж тулгамдсан асуудлуудыг хэлэлцэсний дунд олон улсын өрсөлдөх чадварын эрэмбэ ахиж, үзэх ёстай цөөн орон, үнэ цэнэтэй аялал жуулчлалын бүсэд Монгол орон нэрлэгдэх болов.

Бүх аймгийн төвүүд нийслэл хоттойгоо хурдны замаар холбогдож, аялал жуулчлалын дэд бүтэц эрчимжиж байгаа өнөө үед төсөлт замуудын бүтээн байгуулалт дээр дурдсан цогцолборууд бүхий сууринг дайрснаар аялал жуулчлалын замын сүлжээ, бүсчилсэн хөгжлийн гарц харагдаж байна.

Байгаль, онгондоо ээнэгшишэн шүтлэг, заншил, уламжлал бол дотоодын аялал жуулчлалын томоохон нөөцийг бүрдүүлж байгаа бөгөөд эдийн засгийн эрчимтэй өсөлттэй уялдуулан аль ч улиралд төрсөн нутаг, тахил шүтээнээ эргэдэг, аж ахуйгаа хөгжүүлж, эргэлтэд оруулдаг зэрэг эдийн засгийн өвөрмөц бүтэц зэрэгцэн хөгжиж эхлэв.

Зөвхөн нэг аймгийн тэмдэглэлт ой болоход зочин гийчид, тээврийн хэрэгслийн тоо хэд дахин өсөж, дүйчин өдрүүд, сумын тэмдэглэлт үйл явдал, ах дүүс, суврагын баяр, судрын чуулган, бумба бүтээх, морь тавиж наадам зохион байгуулахад дөрөв, таван мянга гаруй унаа, техник үйлчилж, хүн ам багатай манай оронд аялал жуулчлалаар орлогоо нэмэгдүүлж, гийчин, жуулчинд зориулан үндэсний өвөө сурталчиллах, дээл хэрэглэлээ солилцох, идээ хүнсээ нөөцлөх, ангуучлах зэргээр шинэ бүтээгдэхүүн төрж байна.

Орон нутаг түүхэн алдартай хүмүүсийнхээ талбай, хөшөө дурсгал, бэлэг тэмдгийг хүндэтгэн босгож гадаад орноос бурхан сүншиг бүтээлгэдэг болжээ. Мөн уул, нуруудын эгнэгт шүтэн зураг, хад чулуун байгууламж, бурхант дуганууд бий.

Энэ бүхэн байгальтай хосолсон түүх соёлын дурсгал бүхий музейн бүрдүүлбэрүүд нэгэнт бий болсныг гэрчилнэ.

Зочин гийчдийн анхаарал сонирхлыг татсан дээрх түүх соёлын цогцолборуудыг санаачлах, зураг төслийг зохиох, гарвал үүслийг нээн сэргээхэд хүмүүс, лам хувраг, дархчууд, зохион бүтээгчид, урлагийнхан мэдлэг, хүч, авьяасаа зориулсан. Байгаль, түүх соёлын дурсгалт зүйл байгууламжууд нь ард түмэн, нутаг ус дамжсан том ой санамж, өвийн сан болохыг ЮНЕСКО-оос улс түмний нийтлэг соёлын хэсэг болгон тавьж, түүнтэй хамт бүх төрлийн өвийг сэргээх санаачлагыг дэмжиж байна.

Энэхүү түүх, соёлын цогцолборуудыг орчин цагийн музейн бүрдүүлбэр болгож, соёлын сан хөмрөгийн улсын тооллогод хамруулах, цогцолборууд дээр төрөл бүтээгдэхүүн, үйлчилгээ, танин мэдэхүйн сургалт, сурталчилгааг явуулах нь нутаг, орноо улам гүнзгий мэдэх, өтгөс буурлаа хүндэтгэх, ахуй зан заншилаасаа суралцах, соёлын нууцлаг өвөө таних, уламжлуулан дэлгэрүүлэх цогцолбор үйл ажиллагаа болно.

Ингэснээр орон нутагт музейн орчныг салангад авч үзэхгүй байгалийн тахилгат өнгө төрөх, соёлын дурсгал, төрөл өв уламжлалыг зочин гийчиддээ танилцуулж, омогшил, гярхай сэтгэлгээг хөдөлгөж, уламжлалаа хөгжүүлж байгаа “Хөгжлийн суврага” харагдаж байна. Аймаг, орон нутгийн оролцоо, төсөл хөтөлбөрүүдийг музейн шинэ бодлого, судалгаа шинжилгээний зорилттой уялдуулан дэмжих явдал чухал байна.

Тухайлбал зарим түүх, соёлын цогцолборуудтай орон нутгийн музейн захиргаа нэгдэн ажиллаж тусгайлсан соёлын өвийн арга хэмжээг дагалдуулан зохион байгуулж болох юм.

Аймгийн төв, орон нутгийн төв хаалганы дэргэд нутгийн музей, байгаль, түүх, соёлын цогцолбороуудын маршрут, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт, лавлагаа мэдээлэл бусад сурталчилгаатай зэрэгцэн тавигдсан байвал таатай байна. Засгийн газрын “Шинэ суурин” хөтөлбөрт танилцуулга, сурталчилгаа нь тодорхой байр суурь эзлэх билээ.

#### Дүгнэлт:

Улс төр, түүхэн тодорхой нөхцөлд түүх соёлын цогцолбор, байгууламжууд аяндаа бүтээгдэж, музейн шинэ бүрдүүлбэр хөгжсөн нь аялал жуулчлалыг гадны нөлөөнөөс хамгаалсан юм.

Цаашид Монголын аялал жуулчлалын мастер төлөвлөгөө, зураглалд орон нутгийн бүтээгдэхүүн, брэндүүдийн эдийн засгийн үнэлгээг тооцож, нутгийн иргэд, төр захиргааны ажилтануудад аялал жуулчлалын боловсрол сургалтыг олгох, мэргэжилтний чадварыг интеграцилах зорилтуудыг авч үзэх шаардлагатай.

#### *Библиографический список*

1. БНМАУ-ын Соёлын түүх I, II боть. – Улаанбаатар, 1981 он.
2. Очир, А. Монголын музейн товчоон / А. Очир. – Улаанбаатар, 2004 он.
3. Майдар, Д. Монголын хот, тосгоны турван зураг / Д. Майдар. – Улаанбаатар, 1970 он.
4. Хаш-Эрдэнэ, С. Наследие кочевой цивилизации в экологическом образовании / С. Хаш-Эрдэнэ. – Улан-Батор.
5. Гантомөр, Д. Аялал жуулчлалын үндэс / Д. Гантомөр. – Улаанбаатар, 2003 он.
6. Erbert David.T Heritage, tourism and society Tourism Leisure and Recreation 1995.
7. Getz Don. The Business of Rural Tourism: International Perspectives, 1997.

***Kuo-Ning Chen***

### **CULTURE TOURISM AND THE PRESERVATION, UTILIZATION OF CULTURE HERITAGE-EXPERIENCES ON CULTURAL TOWNS CREATING IN TAIWAN**

Culture tourism (cultural tourism) is the subset of tourism concerned with a region's culture, specifically the architecture, lifestyle of the people in those geographical areas, the tradition customs, the history of those people, their art, festivals, religion, rituals and other elements that helped shape their way of life. Normally cultural tourism includes tourism in urban areas, particularly historic cities, towns and their cultural facilities such as churches, temples, monuments, museums and theatres. It can also include tourism in rural areas showcasing the traditions of indigenous cultural communities, and their values and lifestyle. It is generally agreed that cultural tourists spend substantially more than regular tourists do.

In order to enhance economic development many governments have used cultural heritage to develop their tourism. Cultural tourism can also play a role in regional development; this form of tourism is also becoming generally more popular throughout the world.

When cultural activities and economic benefits linked together then it is not a simple thing, which issues need to be addressed included: contradiction of marketing adaptation and preservation of cultural heritage, popular culture and traditional cultural values of identity choice, appealing to the old for the new creation and design, cultural learning and recreation parallel, equilibrium value of consumer experience and cultural memory etc.

Here are examples in Taiwan choosing for a discussion.

The Southern Branch of National Palace Museum

National Palace Museum (NPM) at Taipei is an internationally famous major museum, its collection of exquisite ancient Chinese artifacts, includes Song, Yuan, Ming, and Ching dynasties emperors'